



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/58/СТА/ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2020 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: nbunchin0719@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.13. Шилэн дансны мэдээлэл	10
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	11
Менежментийн захидал	12
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	14
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Аудит № 17 № 1/2019

танай _____ -ны № _____ -т

Г _____ Г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Баянхонгор сумын 3-р цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус салбарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

• 005020210



Аудитын гол асуудал

Гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн.

Тус цэцэрлэг нь 2019 оны эцэст цалингийн зардлыг тодотгосон байхад 4906,1 мянган төгрөгийн өглөгтэй гарч төсвийг хэтрүүлсэн, тухайн тайлант хугацааны жилийн эцсийн тооллогын бүртгэл баталгаажуагүй санхүүгийн тайланд тусгагдсан бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдлийн үнэн зөв баталгаажуулах боломжгүй, үндсэн хөрөнгө, бараа материалыг орлого авахдаа буруу ангилж бүртгэсэн, 10,0 сая төгрөгийн өртөг бүхий гадна тоглоомыг аваагүй байхад хөрөнгөнд орлого авсан зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Дээрх алдаа, зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн толилуулгын Оршин байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ



D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2.1. Оршил

Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Баянхонгор сумын 3 дугаар Цэцэрлэгийн эрхлэгч Д.Уранчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн 3 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дүгээр сарын 25-ноос 2020 оны 02 дугаар сарын 27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн 3 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дах Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 08 ний өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд

аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлэн өрсөлдөх чадварыг сайжруулах, багш, хүүхдийн бүтээлч хамтын ажиллагааг эрхэмлэн хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ”-д оршино.

Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Баянхонгор сумын “Дуурсах” 3-р багийн 2-5 насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих
- Хамран сургах тойргийнхоо цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хувилбарт сургалт зохион байгуулж, эцэг эх, асран хамгаалагчдад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна

Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 25 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшин “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 401220,8 мянган төгрөгөөс 8024,4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23202,2 мянган төгрөгөөр буюу 3,9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага		10000.0	10000.0
Бараа материал	32454.0	38665.5	6211.5
Үндсэн хөрөнгө	776247.5	791313.4	15065,9
Хуримтлагдсан элэгдэл	-34875.8	-42951.1	-8075.2
Нийт хөрөнгө	773825.6	797027.8	23202.2
Өр төлбөр		4906.1	4906.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	773825.6	792121.7	18296.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	773825.6	797027.8	23202.2

Бараа материалын дансны үлдэгдэл 6211,5 мянган төгрөг өссөн нь хүнсний материал 2191,2 мянга, тусгай зориулалттай материал 3906,3 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. Тусгай зориулалтын материал 3906,3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр ажилчдын нормын хувцас 2798,0 мянга, урлагийн заалны гэрэл, хашаа гэх мэт тохижилтод 1108,3 мянган төгрөгийн хөрөнгө авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 15065,9 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн ЗДТГ-аас 2200,0 гэр үнэ төлбөргүй олгосон, төсвийн хөрөнгөөр 12865.8 мянган төгрөг хөрөнгө бэлтгэснээс шалтгаалжээ.

Тайлант оны эхэнд өр төлбөргүй байсан ба оны эцэст НДШ 1903,2 мянга, ХАОАТ 2932,3 мянга, ҮЭ өглөг 70,6 мянга нийт 4906,1 мянган төгрөгийн өртэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 792121,7 мянган төгрөг болж 18296,1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 18296,1 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсрол олгох хөтөлбөрт зориулан 417316,9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 417316,9 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Нийт зардлын 348188,9 мянган төгрөгийг тусгай зориулалтын санхүүжилтээс, 69128,0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 417226,2 мянган төгрөг буюу 99,7 хувь зарцуулж 90,7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 28 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 28 эрсдэл тодорхойлж нийт 28 горим сорил хэрэгжүүлээ.

Аудитаар нийт 22915,6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 15491,7 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 6120,9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж, санхүүгийн тайланд 1303,0 мянган төгрөгийн залруулга хийлээ.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал
(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	6120,9	
2	Төлбөрийн акт тогтоосон	3	15491,7	
3	Албан шаардлага өгсөн			
	Дүн	4	11612,6	

Аудитаар дараах 11303,0 мянган төгрөгийн алдааг залруулж санхүүгийн тайланд тусгалаа.Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт

Тус цэцэрлэг нь "Хонгорын мөнгөн үсэг" ХХК-тай гэрээ байгуулаагүй 2019 оны 12 сарын 25-нд гадна модон тоглоомын үнэ 10,0 сая төгрөгийг шилжүүлж, тоглоомыг аваагүй байхад үндсэн хөрөнгөнд орлогоор бүртгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 14 дүгээр зүйл 14.4 Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ. 14.4.2 Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага, Сангийн сайдын 388 дугаар тушаалын 4 дүгээр зүйлийн 4.27 Урьдчилж төлсөн төлбөрийг үүссэн тооцоо буюу төлсөн мөнгөн дүнгээр үнэлж бүртгэнэ гэсэн заалтыг зөрчсөн байна

1.2 Эрсдэл

Төсвийн хөрөнгө үрэгдэх, шавшигдах

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд авлагаар тусгах

2 Балансын данстай холбоотой

2.1 Илрүүлэлт

Тухайн тайлант хугацаанд хөрөнгө материал орлого авахдаа бараа материалд 490,0 мянган төгрөгийн өртөг бүхий цаг бүртгэлийн төхөөрөмжийг нярав орлого аваагүй нягтлан бодогч авсан. Үндсэн хөрөнгийн тавилга эд хогшилд 52,5 мянган төгрөгийн өртөг бүхий гэрэл, 35,5 мянган төгрөгийн өртөг бүхий тайзны хашлага, 500,0 мянган төгрөгийн хөшиг орлогодож авсан байна. Мөн бусад биет бус хөрөнгөнд 225,0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программ бүртгэлтэй байна.

Энэ нь Сангийн сайдыг 388 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлалын 4.15 Бараа материал, 4.30 Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт гэсэн заалтуудыг зөрчсөн байна

2.2 Эрсдэл

Бараа материал, үндсэн хөрөнгийг буруу ангилж бүртгэх

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгөнд 490,0 мянган төгрөгийн цаг бүртгэгч орлого авах, үндсэн хөрөнгөнөөс 588,0 мянган төгрөгийн хөрөнгийг хасаж үндсэн хөрөнгөнд авах, бусад биет хөрөнгөөс 225,0 мянган төгрөгийн санхүүгийн программыг хасаж программ хангамжинд бүртгэх

Аудитаар дараах 11612,6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 6120,9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо Үүнд:

1. Тус цэцэрлэг нь “Хонгорын мөнгөн үсэг” ХХК-тай гэрээ байгуулаагүй 2019 оны 12 сарын 25-нд гадна модон тоглоомын үнэ 10,0 сая төгрөгийг шилжүүлж, тоглоомыг аваагүй байхад үндсэн хөрөнгөнд орлогоор бүртгэсэн зөрчил илэрлээ

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2.Тус цэцэрлэг нь “Сүндэр констракшн” ХХК рүү 2019 оны 11 сарын 28-нд багш ажиллагсдын ажлын хувцас 2798,0 мянган төгрөгийг нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 55 тушаалын Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд “Хуулийн дагуу тусгай дүрэмт хувцас хэрэглэх эрх бүхий албан хаагчдын дүрэмт хувцас болон ажлын тусгай зориулалтын нормын хувцас худалдан авах, түүнийг хийлгэхтэй холбогдсон үндсэн болон, туслах материал болон бусад зардал, эмнэлэг, сургуулийн дотуур байр, цэргийн болон бусад байгууллагын хэрэгцээнд ашиглах ор, дэрний хэрэгсэл болон бусад зөөлөн эдлэлийг бүртгэнэ” гэсэн заалтыг тус тус зөрчжээ.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

3. Тус цэцэрлэг нь хоолны зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргалгүй 2693,7 мянган төгрөгийн хүнсний материал нөөцөлж санхүүгийн тайланд тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолын 4-т “Нэг хүүхдэд ногдох дундаж нормативаар санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж зөрүүг тооцож байх” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Аудитаар илэрсэн 6120,9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Цаашид анхан шатны баримт бүрдэлгүй зардал гаргаж байгаа, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх байдлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 89 мэдээллийг хугацаанд нь, 62 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй
1	Бүтэн жил	11	11	5	4	2
2	Хагас жил	4	4		4	
3	Улирал бүр	1	4		4	
4	Сар бүр	3	36	19	17	
5	Тухай бүр	8	96	63	33	
6	Нийт	27	151	89	62	2

Хугацаа хоцроож байршуулсан дараах мэдээллүүд байна.

Бүтэн жилээр хугацаа хоцроосон 4 мэдээллээс байгууллагын батлагдсан төсөв, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, дараа жилийн төсвийн төсөл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө байна.

Хагас жилээр 4 мэдээлэл байршуулахаас 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулжээ. Үүнд Санхүүгийн тайлан, хандив тусламжийн хэмжээ түүний зарцуулалтын тайлан, Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт гэсэн мэдээллүүд байна.

Улирал бүр дээр 4 мэдээлэл байршуулахаас 4 мэдээлэл хугацаа хоцроосон байна. Үүнд төсөвт байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт мэдээлэл байна.

Сар бүр 36 мэдээлэл байршуулахаас 17 мэдээлэл хугацаа хоцроосон. Энэ нь байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт 1-10 сар, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл концессын зүйлийн жагсаалт гүйцэтгэл 4 сар, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 1-4 сар, 9, 12 сард тус тус хоцроосон байна. Тухай бүр байршуулах 96 мэдээллээс 33 мэдээлэл хоцроосон. Үүнд худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн 6 сар, 9 сар, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ 4 сар, 6-12 сар, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг 2 сар, 4-11 сар, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл

1-3 сар, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт 1-10 сар, 12 сарын мэдээллүүдийг тус тус хоцроосон байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитын зөвлөмжөөр Сангийн сайдын 388 дугаар тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн дансны бичилтийн зааврын дагуу хөтлөх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан тухай 2019 оны 10 сарын 23-ны өдрийн 66 албан тоотоор ирүүлсэн байгаа ч санхүүгийн тайланд алдаа давтагдан гарсан нь НББ-ийг хөтлөлтийг сайжруулах шаардлагатай байна.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Баянхонгор сумын 3-р цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Зардлын данстай холбоотой*

1.1. *Илрүүлэлт:*

Ажиллагсдын 11 сарын цалинг нийгмийн даатгалын хэлтэст НДШ-ийг мэдээлэхдээ багш ажилчдын цалингаас 1214,8 мянган төгрөгийг дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 Төсвийг зохистой удирдаж өр төлбөр үүсгэхгүй байх, Нийгмийн даатгалын тухай хуулийн 16,1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ, ХАОАТ-ын хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 1. Энэ хуулийн 14,18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1.1-д заасан хувиар албан татвар ногдуулж холбогдох төсөвт шилжүүлэх гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

1.2. *Эрсдэл:*

Батлагдсан төсөв зориулалтын дагуу зарцуулагдахгүй байх, төсөв хэтрэх

1.3. *Өгсөн зөвлөмж:*

Батлагдсан орон тоо, цалингийн санд багтааж ажиллаж Төсвийн тухай хуулийн хэрэгжүүлж, сар бүр цалинг олгохдоо ажилчдаас суутгасан НДШ, ХАОАТ, ажил олгогчоос төлөх НДШ төлж байх, өглөг авлагагүй ажиллах

1.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Хүлээн зөвшөөрсөн

2. *Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой*

2.1 *Илрүүлэлт*

Үндсэн хөрөнгө хүлээж аваагүй байж орлогоор бүртгэсэн, мөн үндсэн хөрөнгө, бараа материалыг буруу ангилж бүртгэсэн, нярвын тайланг хянаж баталгаажуулдаггүй, жилийн эцсийн тооллогын бүртгэлийг баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, 12 дугаар зүйл 12.2 Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ 12.2.1 Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө, 388 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлалын 4.15 Бараа материал, 4.30 Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт гэсэн заалтуудыг зөрчсөн байна

2.3 Өгсөн зөвлөмж

Анхан шатны баримтыг үндэслэн гүйлгээ хийж байх, эд хөрөнгийн тооллогыг хагас , бүтэн жилээр хийж тооллогыг баталгаажуулж байх, нярвын тайланг сар бүр хянаж хүлээн авч баталгаажуулах Сангийн сайдын 388 тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлалыг мөрдөж ажиллах

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.


Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	32,453,976.24	48,665,495.24
33	АВЛАГА	00.00	10,000,000.00
335	Бусад авлага	00.00	10,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	10,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	32,453,976.24	38,665,495.24
351	Түүхий эд материал	18,764,863.40	22,658,943.40
35110	Тусгай зориулалттай материал	18,747,663.40	22,653,943.40
35130	Эм боох материал	17,200.00	5,000.00
354	Хангамжийн материал	13,689,112.84	16,006,551.84
35410	Бичиг хэргийн материал	1,159,760.00	1,248,760.00
35420	Аж ахуйн материал	6,775,466.00	6,812,016.00
35440	Түлш, шатах тослох материал	00.01	720.01
35450	Барилгын засварын материал	9,000.00	9,000.00
35460	Хүнсний материал	502,493.83	2,693,662.83
35470	Бусад хангамжийн материал	5,242,393.00	5,242,393.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	741,371,656.64	748,362,303.55
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	741,371,656.64	748,362,303.55
392	Биет хөрөнгө	645,971,656.64	652,962,303.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	617,538,936.48	617,538,936.48
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,105,238.40	-1,105,238.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	33,069,548.00	37,286,798.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-23,880,514.85	-29,066,059.85
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,921,526.50	32,760,126.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,390,096.33	-12,206,416.08
39214	Бусад үндсэн хөрөнгө	00.00	6,010,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-73,338.34
39217	Ном	1,817,495.24	1,817,495.24
393	Биет бус хөрөнгө	95,400,000.00	95,400,000.00
39301	Програм хангамж	275,000.00	500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-275,000.00	-500,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	95,625,000.00	95,400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	773,825,632.88	797,027,798.79
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	4,906,104.87
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	4,906,104.87
413	Өглөг	00.00	4,906,104.87
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	4,906,104.87
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	773,825,632.88	792,121,693.92
51	Засгийн газрын хувь оролцоо	773,825,632.88	792,121,693.92
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	222,077,527.70	222,077,527.70
51101	Өмч: - төрийн	222,077,527.70	222,077,527.70
512	Хуримтлагдсан үр дүн	80,563,648.28	98,859,709.32
51210	Өмнөх үеийн үр дүн	80,563,648.28	80,563,648.28
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	18,296,061.04



51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	471,184,456.90	471,184,456.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	773,825,632.88	797,027,798.79

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	363,304,166.00	419,516,895.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,000,000.00	2,199,995.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,000,000.00	2,199,995.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,000,000.00	2,199,995.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,000,000.00	2,199,995.00
141001	Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,015,866.00	69,128,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	357,288,300.00	348,188,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	69,128,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	69,128,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	374,607,458.55	401,220,833.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	374,607,458.55	401,220,833.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	367,069,715.55	400,972,019.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	182,903,287.00	236,639,404.00
210101	Үндсэн цалин	164,195,800.00	236,639,404.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,521,200.00	30,411,700.87
210201	Тэтгэврийн даатгал	15,282,000.00	20,875,636.87
210202	Тэтгэмжийн даатгал	1,802,400.00	2,384,017.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,455,300.00	1,907,212.00
210204	Ажилгүйдлийн даатгал	361,900.00	476,803.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,619,600.00	4,768,032.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,213,508.00	66,263,737.00
210301	Гэрэл, цахилгаан	3,759,710.00	4,009,710.00
210302	Түлш, халаалт	54,106,982.00	53,416,331.00
210303	Цэвэр, бохир ус	6,346,816.00	8,837,696.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,029,352.99	4,975,943.50
210401	Бичиг хэрэг	2,003,340.00	858,300.00
210402	Тээвэр, шатахуун	289,999.99	339,280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,032,373.00	1,286,533.50
210404	Ном, хэвлэл	76,400.00	39,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,278,100.00	2,272,230.00
2105	Нормативт зардал	58,640,505.45	53,124,666.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	89,500.00	85,700.00
210502	Хоол, хүнс	58,551,005.45	53,038,966.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,339,100.00	62,070.00
210604	Урсгал засвар	2,339,100.00	62,070.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	147,600.00
210702	Дотоод албан томилолт	00.00	147,600.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,057,500.00	768,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,057,500.00	568,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,365,262.11	8,578,398.09
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	503,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,735,642.11	8,075,198.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,537,743.00	248,814.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,479,446.00	158,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	761,000.00	158,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	64,263.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	64,263.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	26,451.50
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	26,451.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-11,303,292.55	18,296,061.04
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-18,221,956.97	18,296,061.04

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	362,304,166.00	417,316,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	362,304,166.00	417,316,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	357,288,300.00	348,188,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	69,128,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	69,128,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	362,304,166.00	417,316,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	362,304,166.00	417,316,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	354,766,423.00	417,068,085.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	182,903,287.00	230,368,900.00
210101	Үндсэн цалин	164,195,800.00	203,365,272.00
210102	Нэмэгдэл	7,094,687.00	12,254,228.00
210104	Урамшуулал	11,612,800.00	14,749,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,521,200.00	31,776,100.00
210201	Тэтгэврийн даатгал	15,282,000.00	22,671,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,802,400.00	2,243,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,455,300.00	1,721,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	361,900.00	752,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,619,600.00	4,386,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,213,508.00	66,263,737.00
210301	Гэрэл, цахилгаан	3,759,710.00	4,009,710.00
210302	Түлш, халаалт	54,106,982.00	53,416,331.00
210303	Цэвэр, бохир ус	6,346,816.00	8,837,696.00

2104	Хангамж, бараа материалын зардал	12,474,263.00	4,216,213.50
210401	Бичиг хэрэг	468,100.00	282,300.00
210402	Тээвэр, шатахуун	290,000.00	340,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,032,373.00	1,286,533.50
210404	Ном, хэвлэл	86,400.00	79,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,597,390.00	2,048,280.00
2105	Нормативт зардал	66,535,645.00	58,172,535.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	77,000.00	73,500.00
210502	Хоол, хүнс	58,241,145.00	55,230,135.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,217,500.00	2,868,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,154,000.00	17,245,600.00
210602	Тавилга	00.00	14,203,100.00
210604	Урсгал засвар	1,154,000.00	3,042,500.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	147,600.00
210702	Дотоод албан томилолт	00.00	147,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	925,500.00	768,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	925,500.00	568,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,039,020.00	8,108,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	115,000.00	8,108,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,537,743.00	248,814.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,479,446.00	158,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	761,000.00	158,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	64,263.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	64,263.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	58,297.00	26,451.50
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	58,297.00	26,451.50
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	126,677,527.70	265,754,140.30	122,667,116.64	515,098,784.64
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00



C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	126,677,527.70	265,754,140.30	122,667,116.64	515,098,784.64
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-23,881,511.39	-23,881,511.39
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	222,077,527.70	471,184,456.90	80,563,648.28	773,825,632.88
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	222,077,527.70	471,184,456.90	80,563,648.28	773,825,632.88
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	222,077,527.70	471,184,456.90	80,563,648.28	773,825,632.88
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	18,296,061.04	18,296,061.04
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	222,077,527.70	471,184,456.90	98,859,709.32	792,121,693.92

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	417,316,900.00	417,226,185.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	417,316,900.00	417,226,185.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	417,158,800.00	417,068,085.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	230,368,900.00	230,368,900.00
210101	Үндсэн цалин	196,243,500.00	203,365,272.00
210102	Нэмэгдэл	19,376,000.00	12,254,228.00
210104	Урамшуулал	14,749,400.00	14,749,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,776,100.00	31,776,100.00
210201	Тэтгэврийн даатгал	22,671,700.00	22,671,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,243,100.00	2,243,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,721,700.00	1,721,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	752,700.00	752,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,386,900.00	4,386,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,328,000.00	66,263,737.00
210301	Гэрэл, цахилгаан	4,713,400.00	4,009,710.00


210302	Түлш, халаалт	52,264,600.00	53,416,331.00
210303	Цэвэр, бохир ус	9,350,000.00	8,837,696.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,180,700.00	4,216,213.50
210401	Бичиг хэрэг	282,300.00	282,300.00
210402	Тээвэр, шатахуун	340,000.00	340,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,286,500.00	1,286,533.50
210404	Ном, хэвлэл	79,100.00	79,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,012,800.00	2,048,280.00
2105	Нормативт зардал	58,172,900.00	58,172,535.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	73,800.00	73,500.00
210502	Хоол, хүнс	55,230,200.00	55,230,135.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,868,900.00	2,868,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,282,100.00	17,245,600.00
210602	Тавилга	14,239,600.00	14,203,100.00
210604	Урсгал засвар	3,042,500.00	3,042,500.00
2107	Томилолт, зочны зардал	147,600.00	147,600.00
210702	Дотоод албан томилолт	147,600.00	147,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	768,500.00	768,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	568,500.00	568,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8134000.00	8108900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,134,000.00	8,108,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	158100.00	158100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	158,100.00	158,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	158,100.00	158,100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	417,316,900.00	417,226,185.50
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	348,188,900.00	348,162,448.50
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	348,188,900.00	348,162,448.50
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	69,128,000.00	69,063,737.00
132001	Орон нутгийн төсвөөс	69,128,000.00	69,063,737.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	26.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00
620003	Үйлчлэх ажилтан	08.00	08.00

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:  Н.БҮНЧИНСҮРЭН 2020.02.25

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЭНЯМ 2020.02.25

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ 2020.02.25